



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 6 сарын 24 өдөр

Дугаар 6/693

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 67 дугаар  
цэцэрлэгийн эргэлтийн бус  
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9,286,063.18 /есөн сая хоёр зуун наян зургаан мянга жаран гурван төгрөг арван найман мөнгө/ бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэг /С.Мөнхцэцэг/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 4 нэр төрлийн 989,977.0 /есөн зуун наян есөн мянга есөн зуун далан долоон/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 12 нэр төрлийн 8,296,086.18 /найман сая хоёр зуун ерэн зургаан мянга наян зургаан төгрөг арван найман мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэг /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

11535701751

Тавилга эд хогшлын дүн		2,874,577.00	2,874,577.00	-		
<b>Нийт данснаас хасах хөрөнгийн дүн</b>		<b>9,286,063.18</b>	<b>9,286,063.18</b>	-		
Үүнээс: Худалдах хөрөнгө						
Актлах хөрөнгө			989,977.00			
Татан төвлөрүүлэх хөрөнгө			8,296,086.18			
Худалдсанаас олох орлого						
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/						